

Дээд боловсролын газар
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь	
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		Өөрийн үнэлгээ	ХШ Ү
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ									
1.1.	Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах	-	-	-	-	-	Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан дээд боловсролын салбарт хамаарах арга хэмжээг газрын болон чиг үүргийн дагуу хариуцсан албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангуулж, биелэлтийг хугацаанд нь тайлагнасан. Тухайлбал, Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан 2024 онд багтаан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухай” албан даалгавар № 01-ыг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд дээд боловсролын салбарт хэрэгжүүлэх 5 арга хэмжээний хэрэгжилт ийг зохион байгуулж,	100%	90%

						биелэлтийн хугацаанд нь тайлагнасан. Хавсралт: 1 файл		
1.1.1	Монгол Улсаас дэлхийн шилдэг их сургуулийн эрэмбийн шалгуур үзүүлэлтийг хангахад дэмжлэг үзүүлнэ.	-	Олон улсын эрэмбэд багтсан сургуулийн тоо	-	-	Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагаас дэлхийн шилдэг их сургуулийн эрэмбэд багтсан байна. "Дэлхийд их сургуулиудын эрэмбийг тогтоодог "QS World University Rankings (QS)", "Times Higher Education (THE)", "Academic Ranking of World Universities (ARWU)" зэрэг нэр хүнд бүхий байгууллага байдгаас Times higher Education байгууллагын 2025 оны дэлхийн их сургуулиудын эрэмбэ, чансааг тодорхойлж, 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдөр зарласан дүнгээр Монгол Улсын их сургууль албан ёсоор 1501+ дугаарт эрэмбэлэгдсэн. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны "Дээд боловсролын чанарын үнэлгээ хийх тухай" 240 дүгээр тушаал, 2024 оны "Дээд боловсролын чанарын үнэлгээ хийх тухай" 343 дугаар тушаалын хүрээнд Монгол Улсын их сургуулиас Times Higher Education байгууллагын эрэмбийн суурь болзлыг хангуулахаар оруулсан үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ, зөвлөх үйлчилгээний авах арга хэмжээг зохион байгуулж дэмжлэг үзүүлсэн. https://www.timeshighereducation.com/world-university-rankings/latest/world-ranking#!/length/1/sort_by/rank/sort_order/asc/cols/scores "	100%	90%

							Хавсралт: 2 файл		
1.1.2	Дээд боловсролын сургалтын байгууллагын элсэлтийн хувийг эрэлттэй нийцүүлж, элсэлтийн шалгалтын босго оноог нэмэгдүүлж, элсэгчийн чанарыг сайжруулна.	-	Боловсролын сайдын тушаал	БШУ-ны сайдын 2024 оны 160 дугаар тушаалыг батлуулсан.	-	Дээд боловсролын сургалтын байгууллагын элсэлтийн хувийг эрэлттэй нийцүүлэн судалж, босго онооны тушаалыг гаргана.	Элсэлтийн босго оноог шинэчлэн батлах ажлын хэсгийг Боловсролын сайдын 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/130 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн хурлыг 2 удаа зохион байгуулж, сургуулиудын саналыг хүлээн авч тушаалын төслийг боловсруулан, элсэлтийн шалгалтын босго онооны хэмжээг 490 болгон нэмэгдүүлэн Боловсролын сайдын 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн "Босго оноог тогтоох тухай" А/228 дугаар тушаалыг батлуулсан. Хавсралт: 1 файл	100%	100%
1.2.	Боловсролын хууль тогтоомжид заасан эрх зүйн актыг боловсруулж, батлуулах, хэрэгжилтэд мэргэжил арга зүйгээр хангах, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах	-	-	-	-		Боловсролын багц хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор Боловсролын ерөнхий хууль болон Дээд боловсролын тухай хуульд заасан журам, дүрэм, техникийн зохицуулалтыг боловсруулж, Засгийн газрын тогтоолоор 6, Боловсролын сайдын тушаалаар 14, холбогдох сайд нартай хамтарсан тушаалаар 3 буюу нийт 23 дүрэм, журам, нийтлэг шаардлага, техникийн зохицуулалтыг батлуулж, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажилласан. Тус газраас боловсруулж батлуулсан захиргааны хэм хэмжээний актуудыг нэгтгэн "Дээд боловсролын	100%	100%

						бодлогын шинэчлэл, эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл"-ийг бэлтгэн гаргаж, олон нийтэд сурталчлан таниулсан. Хавсралт: 3 файл			
1.2.3	Дээд боловсролын тухай хуульд заасан журам, дүрэм, стандартыг боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг хангахад мэргэжил арга зүйгээр хангах, олон нийтэд сурталчлан таниулсан байна.	-	Хуульд заасан журам, дүрэм, стандартын тоо	-	Хуульд заасан журам, дүрэм, стандартыг боловсруулж, батлуулсан байна.	Батлуулсан журам, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангахад мэргэжил арга зүйгээр хангах, олон нийтэд сурталчлан таниулсан байна.	Боловсролын багц хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор Боловсролын ерөнхий хууль болон Дээд боловсролын тухай хуульд заасан журам, дүрэм, техникийн зохицуулалтыг боловсруулж, Засгийн газрын тогтоолоор 6, Боловсролын сайдын тушаалаар 14, холбогдох сайд нартай хамтарсан тушаалаар 3 буюу нийт 23 дүрэм, журам, нийтлэг шаардлага, техникийн зохицуулалтыг батлуулж, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажилласан. Тус газраас боловсруулж батлуулсан захиргааны хэм хэмжээний актуудыг нэгтгэн "Дээд боловсролын бодлогын шинэчлэл, эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл"-ийг бэлтгэн гаргаж, олон нийтэд сурталчлан таниулсан. Хавсралт: 6 файл	100%	100%
1.3.	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ	-	-	-	-	"Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 4.1.10.2-2 дахь хэсэгт "Их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдвийг	100%	90%	

					<p>тусгах” гэж заасны дагуу Боловсрол, шинжлэх ухааны дэд сайдын 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" 16/675 тоот албан бичгийг дээд боловсролын сургалтын 64 байгууллагад хүргүүлж, түүний хэрэгжилтийн тайланг хүлээн авч нэгтгэн Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. Дээд боловсролын газар, АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран дээд боловсролын сургалтын байгууллагуудыг оролцуулан “Мэргэжлийн ёс зүйн боловсрол, тулгамдсан асуудал” сэдэвт хэлэлцүүлгийг 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулсан. Мөн ТНБД-ын 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" 2/1408 тоот албан бичгээр “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2023-2030”-д заасан хэрэгжилтийг хангах чиглэл хүргүүлсэн бичгийг дээд боловсролын сургалтын 65 байгууллагад, хүргүүлсэн. Авлигатай тэмцэх газраас 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн “Мэргэжил, арга зүйн удирдамжаар хангаж ажиллах тухай” 04/16257 тоот албан бичиг ирүүлснийг Боловсролын яамны Дээд боловсролын газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" 4/1743 тоот албан бичгээр нийт дээд боловсролын сургалтын 65 байгууллагад хүргүүлэн Авлигатай</p>	
--	--	--	--	--	--	--

							тэмцэг үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Хавсралт: 6 файл		
1.3.4	Дээд боловсролын сургалтын байгууллагын эрх зүйн хөтөлбөр, хичээлийн сургалтын агуулгад авлигыг үл тэвчих, ёс суртахууныг төлөвшүүлэх агуулга, сэдвийг тусгах.	-	Авлигыг үл тэвчих, ёс суртахууныг төлөвшүүлэх агуулга, сэдвийг багтаасан сургалтын хөтөлбөр	-	-	1	“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 4.1.10.2-2 дахь хэсэгт “Их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сэдвийг тусгах” гэж заасны дагуу Боловсрол, шинжлэх ухааны дэд сайдын 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн “Чиглэл хүргүүлэх тухай” 16/675 тоот албан бичгийг дээд боловсролын сургалтын 64 байгууллагад хүргүүлж, түүний хэрэгжилтийн тайланг хүлээн авч нэгтгэн Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 9.3.1-д заасан “Бүх түвшний сургалтын агуулга, хөтөлбөрт авлигыг үл тэвчих, ёс суртахууныг төлөвшүүлэх агуулга, сэдвийг олон улсын туршлага, үндэсний онцлогт нийцүүлэн тусгаж, дүн шинжилгээ хийж, үр нөлөөг үнэлэх” ажлын хүрээнд мэргэжлийн ёс зүйн хичээлийн судлагдахуун гарын авлага, багшлах боловсон хүчин, тухайн хичээлийн багц цаг, сүүлийн 5 жилд их дээд сургуулиудад мэргэжлийн ёс зүйн хичээл хэрхэн судлагдаж байгаа талаар судалгааг эрчимжүүлэх, тулгамдаж буй	100%	90%

							<p>асуудал, гарц шийдлийн талаар хэлэлцэж, цаашид хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох зорилгоор “Мэргэжлийн ёс зүйн боловсрол, тулгамдсан асуудал” сэдэвт хэлэлцүүлгийг АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдөр дээд боловсролын сургалтын байгууллагуудыг оролцуулан зохион байгуулсан. Мөн Боловсролын яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дээд боловсролын сургалтын байгууллагаас “Их дээд сургуулийн оюутан, залуусын шударга байдлын түвшинг нэмэгдүүлэх, их, дээд сургуулийн орчинд шударга ёсны үзэл санааг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэн үр дүнг тооцон ажиллах” гэж заасан. Иймд дээрх хөтөлбөр, төлөвлөгөөнд заасан ажлыг сургуулийн орчинд үр дүнтэй хэрэгжүүлж, хэрэгжилтийн тайланг 2024 оны 12 дугаар сард багтаан авч АТГ-т тайланг нэгтгэн хүргүүлэхээр ажиллаж байна. МУИС-иас эхний тайлан ирүүлсэн.</p> <p>Хавсралт: 8 файл</p>		
1.3.5	Дээд боловсролын сургалтын байгууллагаас оюутнуудад чиглэсэн сургалтын	-	Салбар, мэргэжлийн онцлог бүхий авлигын эрсдэлд суурилсан	-	-	1 арга хэмжээ	Боловсрол, шинжлэх ухааны дэд сайдын 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" 16/675 тоот албан бичгээр "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт"-ийг хангаж ажиллах чиглэлийг дээд	100%	100%

	хөтөлбөр, гарын авлага боловсруулах ад мэргэжил арга зүйгээр ханган ажиллана.		сургалтын хөтөлбөр, гарын авлага			<p>боловсролын сургалтын 64 байгууллагад хүргүүлж, судалгаа тайланг нэгтгэн авч АТГ-ын Соён гэгээрүүлэх хэлтэст хүргүүлж ажилласан. Мөн ТНБД-ын 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" 2/1408 тоот албан бичгээр "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2023-2030"-д заасан хэрэгжилтийг хангах чиглэл хүргүүлсэн бичгийг дээд боловсролын сургалтын 65 байгууллагад, хүргүүлсэн. Авлигатай тэмцэх газраас 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн "Мэргэжил, арга зүйн удирдамжаар хангаж ажиллах тухай" 04/16257 тоот албан бичиг ирүүлснийг Боловсролын яамны Дээд боловсролын газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" 4/1743 тоот албан бичгээр нийт дээд боловсролын сургалтын 65 байгууллагад хүргүүлэн Авлигатай тэмцэг үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">Хавсралт: 3 файл</p>			
Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ									
3.1.	Дээд боловсролын сургалтын байгууллагын хөгжил, үйл ажиллагааг удирдлага,	-	-	-	-	Дээд боловсролын сургалтын байгууллагын хөгжил, үйл ажиллагааг удирдлага, зохицуулалтаар хангах чиглэлээр Боловсролын ерөнхий хууль болон Дээд боловсролын тухай хуульд заасан журам, дүрэм, техникийн	100%	100%	

	зохицуулалта ар хангах						зохицуулалтыг боловсруулж, Засгийн газрын тогтоол, Сайдын тушаалаар нийт 12 дүрэм, журам, нийтлэг шаардлага, техникийн зохицуулалтыг батлуулж, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажилласан. Тухайлбал: Дээд боловсролын сургалтын байгууллагын үлгэрчилсэн дүрэм, Дээд боловсролын сургалтын байгууллагад тавих техникийн зохицуулалт, Төрийн өмчийн сургалтын байгууллагын дундын удирдах зөвлөлийн дүрэм, "Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа хөрөнгийн төрийн өмчийн тогтмол зардлыг санхүүжүүлэх журам"-ыг батлуулснаар дээд боловсролын сургалтын байгууллагуудын сургалт, судалгааны чанарыг нэмэгдүүлэх, сургалтын төлбөрийн өсөлтийг сааруулахад эерэг нөлөөллийг үзүүлнэ гэж тооцож байна. Хавсралт: 2 файл		
3.1.1	Дээд боловсролын сургалтын байгууллагын үлгэрчилсэн дүрмийг батлуулна.	-	Сайдын тушаал	Дүрмийн төслийг боловсруулсан	Дүрмийг батлуулсан байна.	-	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/53 дугаар тушаалаар "Дээд боловсролын сургалтын байгууллагын үлгэрчилсэн дүрэм"-ийг батлуулсан. Үлгэрчилсэн дүрмийн төслийг боловсруулахдаа 2007 оны	100%	100%

						<p>үлгэрчилсэн дүрэмд Боловсролын ерөнхий хууль (10, 11, 12, 13, 18) болон Дээд боловсролын тухай хуулийн холбогдох заалт (2, 5, 6.2, 11, 13, 14, 15, 16, 22, 23, 28, 30, 31, 32 заалт)-д нийцүүлэн өөрчлөлт оруулсан. Тухайлбал, үлгэрчилсэн дүрмийн төслийн 2.3.1-т дээд боловсролын сургалтын байгууллагын оноосон нэрийг онооход Дээд боловсролын тухай хуулийн 6.2, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 13.3, Иргэний хуулийн 27.3-т заасныг мөрдөхийг зааж, “олон улсын” гэсэн үгийг ашиглах нөхцөлийг 2.3.3-д тусган оруулсан. Түүнчлэн, өмнөх дүрэмд нэг бүлэгт оруулсан байсан удирдлага, зохион байгуулалтыг асуудлыг салган хоёр бүлэгт оруулсан. Мөн дүрмийн төслийн 4.5-т суралцагчийг гэмт хэрэг, мансуурах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах, тайлагнах үүргийг хариуцах нэгжийг зааж, 3.11, 6.7, 6.4-т гүйцэтгэх удирдлага, багш, ажилтан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ улс төр, эдийн засаг, шашны аливаа нөлөөлөлд орохгүй, суралцагчийн эрх ашгийг дээдэлж, шударга ёсыг эрхэмлэх шаардлагыг тусгав. Түүнчлэн шинэчлэн баталсан дүрэмд дээд боловсролын сургалтын байгууллагын судалгааны үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтыг 5 дугаар</p>	
--	--	--	--	--	--	--	--

							бүлэгт оруулсан болно. Хавсралт: 1 файл		
3.1.2	Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа хөрөнгийн төрийн өмчийн тогтмол зардлыг олгох журмыг батлуулна.	-	Засгийн газрын тогтоол	Журмын төслийг боловсруулсан	Журмыг батлуулсан байна.	-	Дээд боловсролын тухай хуулийн 32.2.3-т "төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа хөрөнгийн төрийн өмчийн тогтмол зардал"-ыг олгох замаар дээд боловсролын сургалтын байгууллагад улсын төсвөөс дэмжлэг үзүүлнэ" гэж хуульчилсан тул төрийн өмчийн их, дээд сургуулиудад тогтмол зардлыг олгох харилцааг зохицуулах "Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа хөрөнгийн төрийн өмчийн тогтмол зардлыг санхүүжүүлэх журам"-ыг Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 164 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлуулсан. Журам нь 4 бүлэг, 29 заалттай бөгөөд журмын хамрах хүрээнд 2024 оны байдлаар сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн өмчийн 16 дээд боловсролын сургалтын байгууллага орж байгаа болно. Уг журмыг батлуулснаар төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагуудын сургалт, судалгааны чанарыг нэмэгдүүлэх, сургалтын төлбөрийн өсөлтийг сааруулахад эерэг нөлөөллийг үзүүлнэ гэж тооцож байна.	100%	100%

							Хавсралт: 1 файл		
3.1.3	Төрийн болон орон нутгийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулах журмыг батлуулна.	-	Сайдын тушаал	Журмын төсөл боловсруулсан	Журмыг батлуулсан байна.	-	Боловсролын сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдийн "Журам батлах тухай" А/145 дугаар тушаалаар "Төрийн болон орон нутгийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулах журам"-ийг баталсан. Хавсралт: 1 файл	100%	100%
3.1.4	Төрийн өмчийн сургалтын байгууллагын дундын удирдах зөвлөлийн дүрмийг батлуулна.	-	Засгийн газрын тогтоол	Дүрмийн төслийг боловсруулсан.	Дүрмийг батлуулсан байна.	-	Дундын удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 49 дүгээр тогтоолоор батлуулсан. Дундын удирдах зөвлөлийг Монгол Улсын тэргүүлэх их сургуулиуд болох Монгол Улсын их сургууль, Монгол Улсын Боловсролын их сургууль, Хөдөө аж ахуйн их сургууль, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Соёл, урлагийн их сургууль, Шинжлэх ухаан, технологийн их сургууль зэрэг зургаан их сургуулийн хэмжээнд байгуулсан. Дундын удирдах зөвлөл нь орон тооны бус зөвлөл байх бөгөөд зөвлөл нь Ажлын албатай байна. Ажлын албаны үйл ажиллагааны зардлыг зургаан их сургуулиудаас гаргуулах зохицуулалтыг хийж, Ажлын албанд (дарга, ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн 3) нийт 5 хүн ажиллах	100%	100%

							тооцоог гаргасан. Хавсралт: 1 файл		
3.1.5	Дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөлтийн журмыг батлуулна.	-	Сайдын тушаал	Журмын төслийг боловсруулсан.	Журмыг батлуулсан байна.	-	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/143 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар "Дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөлтийн журам"-ыг шинэчлэн батлуулсан. Хавсралт: 1 файл	100%	100%
3.1.6	Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн төрийн төлөөллийг томилох тушаал батлуулна.	-	Сайдын тушаал	БШУС-ын 2023 оны 576 дугаар тушаалаар баталсан дүрэм	Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн төрийн төлөөллийг томилсон байна.	-	Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын 12 байгууллагын удирдах зөвлөлийн төрийн төлөөллийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/188 дугаар тушаалаар батлуулсан. Хавсралт: 1 файл	100%	100%
3.1.7	Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн үнэлгээний үлгэрчилсэн журмыг батлуулна.	-	Сайдын тушаал	Журмын төслийг боловсруулсан.	Журмыг батлуулсан байна.	-	Боловсролын сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдийн "Журам шинэчлэн батлах тухай" А/144 дугаар тушаалаар "Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн үнэлгээний үлгэрчилсэн журам"-ыг баталсан. Хавсралт: 1 файл	100%	100%
3.1.8	Дээд боловсролын сургалтын	-	Засгийн газрын тогтоол	Техникийн зохицуулалтын төслийг	Техникийн зохицуулалтыг батлуулсан	-	Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн "Техникийн зохицуулалт батлах тухай" 253	100%	100%

	байгууллагад тавих техникийн зохицуулалтыг боловсруулан батлуулна.			боловсруулж эхэлсэн.	байна.		дугаар тогтоолоор "Дээд боловсролын сургалтын байгууллагад тавих техникийн зохицуулалт"-ыг батлуулсан. Хавсралт: 1 файл		
3.1.9	Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын Удирдах зөвлөлд чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах зохицуулалтыг гүйцэтгэнэ.	-	Сайдын тушаал	БШУ-ны сайдын 2024 оны 188 дугаар тушаалыг батлуулсан.	-	Төрийн өмчийн зарим их сургуулийн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулна.	Дээд боловсролын тухай хууль болон "Дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн нийтлэг дүрэм"-ийн хүрээнд удирдах зөвлөлийн чиг үүргийг хэрэгжүүлэхийг Удирдах зөвлөлийн үүсгэн байгуулагчийн төлөөлөлийн нэрсийг Авилгалтай тэмцэх газарт 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр 1/1141 тоот албан бичгээр хүргүүлсэн. Авилгалтай тэмцэх газраас "Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан тухай" 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдөр 01/16294 дүгээр албан бичиг ирсэн. Боловсролын сайдын "Монгол Улсын их сургуулийн Удирдах зөвлөлийн үүсгэн байгуулагчийн төлөөллийг шинэчлэн батлах тухай" А/163, "Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн үүсгэн байгуулагчийн төлөөллийг шинэчлэн батлах тухай" А/172, "Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Удирдах зөвлөлийн үүсгэн байгуулагчийн төлөөллийг шинэчлэн батлах тухай" А/168, "Монгол Улсын боловсролын их сургуулийн Удирдах зөвлөлийн үүсгэн байгуулагчийн төлөөллийг	100%	100%

							<p>шинэчлэн батлах тухай" А169, Монгол-Германы технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн үүсгэн байгуулагчийн төлөөллийг шинэчлэн батлах тухай" А/170, "Хөдөө аж ахуйн их сургуулийн Удирдах зөвлөлийн үүсгэн байгуулагчийн төлөөллийг шинэчлэн батлах тухай" А/159 дүгээр тушаалууд батлагдсан. Их сургуулиудын Удирдах зөвлөлийн төрийн төлөөллүүдтэй Боловсролын сайд П.Наранбаяр уулзаж, цаашид ажиллах ажлын төлөвлөгөөний чиглэл, өнөөгийн байдлыг талаар хэлэлцсэн. Их сургуулиудын Удирдах зөвлөлийн төрийн төлөөллийг баталсан тушаалуудыг 2024 оны 10 дугаар сарын 31-ний 4/1884, 4/1885, 4/1886, 4/1887, 4/1888 тоот албан бичгүүдээр хүргүүлсэн.</p> <p>Хавсралт: 1 файл</p>		
3.1.1 0	Дээд боловсролын сургалтын байгууллага болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хийх журмын төслийг боловсруулан батлуулна.	-	Сайдын тушаал	-	Журмын төслийг боловсруулсан.	Журмыг батлуулсан байна.	“Мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын сургалтын байгууллага болон хөтөлбөрийг магадлан итгэмжлэх, магадлан итгэмжлэл хийх журам”, “Мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын сургалтын байгууллага болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэх, магадлан итгэмжлэл хийх шинжээчид тавих шаардлага”-ын төслийг тус тус боловсруулж, ТНБД-ын 2023 оны А/146 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд	90%	70%

							<p>хэлэлцүүлж, яамны цахим хуудсанд байршуулан 2024.09.23-2024.10.23-ны хооронд олон нийтээс санал авсан. Төсөлд ирүүлсэн саналын хүрээнд Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн удирдлага, холбогдох мэргэжилтнүүдтэй 2024.11.07, 15-ны өдрүүдэд хэлэлцүүлэг хийж, шинэчилсэн төслийг яамны албан хэрэг хөтлөлтийн систем /эйбл/-д оруулан холбогдох нэгжийн дарга нарт танилцуулан санал авч байна. Журам, шаардлагын төсөл Сайдын тушаалаар батлагдах шатандаа байна. Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхээр хүргүүлэх танилцуулга болон нөлөөллийн шинжилгээг боловсруулсан.</p> <p>Хавсралт: 3 файл</p>		
3.1.1 1	Их сургууль салбар дундын судалгааны нээлттэй лаборатори болон технологийн туршилт, зүгшрүүлэлтийн нэгдсэн сүлжээг байгуулж ажиллуулах журмын төслийг	-	Сайдын тушаал	-	-	Журмын төслийг боловсруулсан байна.	<p>Боловсролын сайдын 2024 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/93 дугаар тушаалаар "Их сургууль салбар дундын судалгааны нээлттэй лаборатори болон технологийн туршилт, зүгшрүүлэлтийн нэгдсэн сүлжээг байгуулж ажиллуулах журам"-ыг боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр хуралдаж, журмын төслийг боловсруулах гол зарчим, тусгах асуудлуудыг хэлэлцэн, чиг үүргийн дагуу саналаа боловсруулахаар</p>	100%	100%

	боловсруулн а.					<p>хэлэлцсэн. Журмын төслийг боловсролын яамны вэб сайтад 2024 оны 10 сарын 15-ны өдрөөс эхлэн сарын хугацаанд тавьсан. Монгол улсад ашиглагдаж байгаа эрдэм шинжилгээний 300 орчим лаборатори байна гэсэн судалгаа байна. Эдгээрээс төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн лабораториуд суурь судалгааны чиглэлийн туршилт судалгаа гол төлөв хийдэг бол төрийн өмчийн их дээд сургуулийн лабораториуд сургалт, судалгаа хосолсон болон сорилтын лабораториуд байна. Ажлын хэсэг журам боловсруулах явцад Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын 4.2.4.2.-д “болон”, “эсхүл”, “буюу” гэсэн холбоос үг нь нэг бол, үгүй бол, аль нэг нь гэсэн утгаар өгүүлбэрийн гишүүдийг зэрэгцүүлэн холбоно” гэж заасанг болон Нөгөөтэйгээр инновацийн тухай хуульд "технологийн туршилт, зүгшрүүлэлт" гэж боловсруулсан технологи, бүтээгдэхүүний загварыг үйлдвэрлэлийн нөхцөлд турших, боловсронгуй болгох, технологийн баримтжуулалт хийх үйл ажиллагаа гэж тусгасанг хэлэлцэн санал гаргаж, хуулийн зөвлөгөө авсаны дагуу “Их сургууль салбар дундын судалгааны нээлттэй лаборатори байгуулж ажиллуулах журам” гэсэн нэрээр боловсруулсан.Энэхүү журам батлагдсанаар судалгаа,</p>	
--	-------------------	--	--	--	--	---	--

							шинжилгээ, сорилт, баталгаажуулалтын үр дүнг олон улсад хүлээн зөвшөөрөгдөх түвшинд хүргэх, үндэсний болон олон улсын магадлан итгэмжлэлийг бий болгох, тоног төхөөрөмж, хүний нөөцийн ашиглалтыг нэмэгдүүлэх, лабораториудын хоорондын уялдаа холбоог сайжруулах боломжийг бүрдүүлнэ гэж үзэж байна. Хавсралт: 2 файл		
3.1.1 2	Эрэлттэй тэргүүлэх мэргэжлийн чиглэлийн жагсаалтад дүн шинжилгээ хийж, засгийн газрын тогтоолын төслийг шинэчлэн боловсруулах, холбогдох яамдаас санал авч нэгтгэн танилцуулах.	-	Засгийн газрын тогтоолын төсөл	Засгийн газрын 2023 оны 115 дугаар тогтоол	-	Эрэлттэй тэргүүлэх мэргэжлийн чиглэлийн жагсаалтын Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, танилцуулсан байна.	Боловсролын сайдын 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/120 дугаар тушаалаар "Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн жагсаалтын төсөл боловсруулах ажлын хэсэг"-ийг баталсан. Ажлын хэсгийн гишүүд холбогдох бусад яамдаас ирүүлсэн саналыг үндэслэн тус аргачлалын дагуу "Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлийн жагсаалт"-ыг шинэчлэн боловсруулж, БМИҮЗ-ийн мэргэжлийн зөвлөлд хүргүүлэн хянуулж, Засгийн газрын тогтоолын төсөл бэлтгэн боловсруулж танилцуулав. Хавсралт: 2 файл	100%	100%
3.2.	Иргэний сурч боловсрох эрх, тэгш боломж, чанартай боловсрол эзэмших,	-	-	-	-		Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/50 тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг төрийн болон хувийн өмчийн 77 их, дээд сургууль, харьяа салбар сургуульд нэг сарын хугацаатай хяналт шалгалтын ажил хийж, дүгнэлтээ	100%	100%

	эрүүл, аюулгүй орчин нөхцөлийг хангуулах, салбарын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн баталсан нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог бэхжүүлэх					гаргасан. Боловсрол сургалтын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн баримт бичгүүд, хууль, тогтоомж, дүрэм журам, стандарт, норм нормативын хэрэгжилт, дээд боловсролын удирдлага мэдээллийн системийн бүртгэл, мэдээллийн баяжуулалт зэрэгт танилцсан бодит байдалтай газар дээр нь танилцан үнэлэлт дүгнэлт өгсөн. Хавсралт: 3 файл			
3.2.1 3	Дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын орчны стандартын хэрэгжилтийг хяналт шалгалтыг хамтран хийнэ.	-	Хууль тогтоомжийн хэрэгжилт	-	Дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын орчны стандартын хэрэгжилтийг шалгах ажлын хэсэгт ажиллана.	-	БШУ-ны сайдын 2024 оны А/50 тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг төрийн болон хувийн өмчийн 77 их, дээд сургууль, харьяа салбар сургуульд нэг сарын хугацаатай хяналт шалгалтын ажил хийж, дүгнэлтээ гаргасан. Боловсрол сургалтын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн баримт бичгүүд, хууль, тогтоомж, дүрэм журам, стандарт, норм нормативын хэрэгжилт, дээд боловсролын удирдлага	100%	100%

							мэдээллийн системийн бүртгэл, мэдээллийн баяжуулалт зэрэгт танилцсан бодит байдалтай газар дээр нь танилцан үнэлэлт дүгнэлт өгсөн. Хавсралт: 1 файл		
3.3.	Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн шалгуур, шаардлагыг шинэчлэх	-	-	-	-	-	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн "Нийтлэг шаардлага шинэчлэн батлах тухай" А/147 дугаар тушаалаар "Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага"-ыг баталсан. Хавсралт: 1 файл	100%	100%
3.3.1	Дээд боловсролын мэргэжлийн чиглэл, хөтөлбөрийн индексийг шинэчлэн батлуулна.	-	Сайдын тушаал	Мэргэжлийн чиглэл, индексийн жагсаалтын төслийг боловсруулсан.	Мэргэжлийн чиглэл, индексийн жагсаалтыг шинэчлэн батлуулсан байна.	-	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн "Мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индекс шинэчлэн батлах тухай" А/146 дугаар тушаалаар "Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индекс"-ийг баталсан. Хавсралт: 1 файл	100%	100%
3.3.1 4	Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагыг батлуулна.	-	Сайдын тушаал	Нийтлэг шаардлагын төслийг боловсруулсан.	Нийтлэг шаардлагыг батлуулсан байна.	-	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн "Нийтлэг шаардлага шинэчлэн батлах тухай" А/147 дугаар тушаалаар "Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага"-ыг баталсан. Хавсралт: 1 файл	100%	100%

3.3.1 6	Сургалтын агуулгыг багц цагаар тооцох, багц цагийг дүйцүүлэх журмыг батлуулна.	-	Сайдын тушаал	Журмын төслийг боловсруулсан	Журмыг батлуулсан байна.	-	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" А/216 дугаар тушаалаар "Дээд боловсролын сургалтын агуулгыг багц цагаар тооцох, багц цагийг дүйцүүлэх журам"-ыг баталсан. Хавсралт: 1 файл	100%	100%
3.4.	Гүйцэтгэлийн үзүүлэлтэд үндэслэн дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал, үндэсний эрэмбэ, чансааг тогтоох арга хэмжээг зохион байгуулах	-	-	-	-	-	Дээд боловсролын тухай хуулийн 12.9-д "Дээд боловсролын сургалтын байгууллагын үндэсний эрэмбэ, чансаа, хөтөлбөрийн чанарыг цахим сангийн мэдээлэлд үндэслэн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний байгууллагатай хамтран 2 жил тутам тогтоон олон нийтэд мэдээлнэ." гэж хуульчилсны дагуу их, дээд сургуулийн үндэсний эрэмбэ, чансааг анх удаа урьдчилсан байдлаар тогтоож 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр олон нийтэд нээлттэй зарласан. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/50 дугаар тушаалаар "Дээд боловсролын сургалтын байгууллагын 2022-2023 оны хичээлийн жилийн гүйцэтгэлийн үзүүлэлтийг баталгаажуулах, дүгнэх ажлын хэсэг" байгуулагдаж 2024.02.25-2024.04.22-ны өдрүүдэд их, дээд сургуулиуд дээр ажиллаж, байгууллагын гүйцэтгэлийн үзүүлэлтийг хянан баталгаажуулсан. Ажлын хэсгийн хянан баталгаажуулсан Боловсрол,	100%	100%

							<p>шинжлэх ухааны сайдын 2024 оны А/343 дугаар “Дээд боловсролын чанарын үнэлгээ хийх тухай” тушаалаар дээд боловсролын сургалтын байгууллагын баталгаажуулсан дата өгөгдлийн дагуу тооцооллыг хийж дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээ, үндэсний эрэмбийг эцэслэн тогтоох үйл ажиллагааг зохион байгуулсан. Дээд боловсролын чанарын үнэлгээ хийсэн үйл ажиллагааны тайлангийн хурлыг Боловсролын яам, Боловсролын үнэлгээний төв хамтран 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр дээд боловсролын сургалтын байгууллагын 82 төлөөллийг оролцуулан зохион байгуулсан.</p> <p style="text-align: right;">Хавсралт: 4 файл</p>		
3.4.1 7	Дээд боловсролын сургалтын байгууллагын ангиллыг тогтоох арга хэмжээний бэлтгэл ажлыг зохион байгуулна.	-	Техникийн зохицуулалтын дагуу ангилал тогтоох удирдамжийн төсөл	Техникийн зохицуулалтын төслийг боловсруулсан.	Техникийн зохицуулалтын Засгийн газрын тогтоол батлуулсан байна.	Техникийн зохицуулалтын дагуу ангиллыг тогтоох арга хэмжээний бэлтгэл ажлыг зохион байгуулна.	Боловсролын ерөнхий хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу дээд сургуулийг их сургууль, эсхүл коллеж болгох шилжилтийн үйл ажиллагааг 2025 оны нэгдүгээр улиралд зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд холбогдох байгууллагуудаас ажлын хэсэгт орох төлөөллийн нэрсийг албажуулан авсан. “Дээд боловсролын сургалтын байгууллагад тавих техникийн зохицуулалт”-ын шаардлага, шалгуур үзүүлэлтийн тоон мэдээлэл хүлээн авах хүснэгт болон тооцох	100%	100%

							<p>аргачлалыг боловсруулсан. Боловсролын сайдын "Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамж батлах тухай" тушаалын төслийг боловсруулж, хавсралтаар дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамж болон шаардагдах зардлыг тус тус батлуулах яамны албан хэрэг хөтлөлтийн системээр нэгжийн дарга нарт танилцуулж байна. "Дээд боловсролын сургалтын байгууллагад тавих техникийн зохицуулалт"-ын дагуу ангилал тогтоох, дүгнэлт гаргах ажлыг 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс 2025 оны 04 дүгээр сарын 01-ний хооронд зохион байгуулна.</p> <p style="text-align: right;">Хавсралт: 2 файл</p>		
3.4.1 8	Дээд боловсролын сургалтын байгууллагын эрэмбэ тогтоох арга хэмжээг зохион байгуулна.	300,0	Дээд боловсролын сургалтын байгууллагын эрэмбэ	2023 оны А/240 тушаалаар шалгуур үзүүлэлтийг баталсан. 2023 оны 10 дугаар сард урьдчилсан эрэмбэ тогтоож, олон нийтэд мэдээлсэн.	Дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үзүүлэлтийг баталгаажуулна.	Дээд боловсролын сургалтын байгууллагын эрэмбэ тогтоох арга хэмжээг зохион байгуулна.	Дээд боловсролын тухай хуулийн 12.9-д "Дээд боловсролын сургалтын байгууллагын үндэсний эрэмбэ, чансаа, хөтөлбөрийн чанарыг цахим сангийн мэдээлэлд үндэслэн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний байгууллагатай хамтран 2 жил тутам тогтоон олон нийтэд мэдээлнэ." гэж хуульчилсны дагуу их, дээд сургуулийн үндэсний эрэмбэ, чансааг анх удаа урьдчилсан байдлаар тогтоож 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр олон нийтэд нээлттэй зарласан.	100%	100%

						<p>Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/50 дугаар тушаалаар "Дээд боловсролын сургалтын байгууллагын 2022-2023 оны хичээлийн жилийн гүйцэтгэлийн үзүүлэлтийг баталгаажуулах, дүгнэх ажлын хэсэг" байгуулагдаж 2024.02.25-2024.04.22-ны өдрүүдэд их, дээд сургуулиуд дээр ажиллаж, байгууллагын гүйцэтгэлийн үзүүлэлтийг хянан баталгаажуулсан. Ажлын хэсгийн хянан баталгаажуулсан Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/343 дугаар "Дээд боловсролын чанарын үнэлгээ хийх тухай" тушаалаар дээд боловсролын сургалтын байгууллагын баталгаажуулсан дата өгөгдлийн дагуу тооцооллыг хийж дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээ, үндэсний эрэмбийг эцэслэн тогтоох үйл ажиллагааг зохион байгуулсан. Дээд боловсролын чанарын үнэлгээ хийсэн үйл ажиллагааны тайлангийн хурлыг Боловсролын яам, Боловсролын үнэлгээний төв хамтран 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр дээд боловсролын сургалтын байгууллагын 82 төлөөллийг оролцуулан зохион байгуулсан.</p> <p style="text-align: right;">Хавсралт: 4 файл</p>		
3.5.	Дээд боловсролын салбарын	-	-	-	-	Зөвшөөрлийн цахим системд Боловсролын яамнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий 65 дээд	100%	100%

	цахимаар үзүүлж буй үйлчилгээний тоо, чанарыг нэмэгдүүлж, лавлагаа, тодорхойлолтын санг нэмэгдүүлнэ.					боловсролын сургалтын байгууллагын тусгай зөвшөөрлийн мэдээллийн оруулж, цахим лавлагаа гаргаж эхэлсэн. Зөвшөөрлийн цахим системд дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, шинэ мэргэжлээр сургалт явуулах энгийн зөвшөөрлийн хүсэлт гаргах, мэргэжлийн индексийн шинэчлэл болон улсын тэмдэгтийн хураамж төлөх цэсийг хөгжүүлэх ажлын даалгавар боловсруулж системийн хөгжүүлэлт хийгдэж дууссан, Зөвшөөрлийн цахим системээр хүсэлт хүлээн авах боломжтой болсон. Хавсралт: 1 файл		
3.5.1 9	Дээд боловсролын салбарын цахимаар үзүүлж буй үйлчилгээний тоо, чанарыг нэмэгдүүлж, лавлагаа, тодорхойлолтын санг нэмэгдүүлнэ.	-	Зөвшөөрлийн цахим мэдээллийн сан	-	-	Дээд боловсролын сургалтын байгууллагын зөвшөөрлийн цахим мэдээллийн системийг хөгжүүлсэн байна. Зөвшөөрлийн цахим системд Боловсролын яамнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий 65 дээд боловсролын сургалтын байгууллагын тусгай зөвшөөрлийн мэдээллийн оруулж, цахим лавлагаа гаргаж эхэлсэн. Зөвшөөрлийн цахим системд дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, шинэ мэргэжлээр сургалт явуулах энгийн зөвшөөрлийн хүсэлт гаргах, мэргэжлийн индексийн шинэчлэл болон улсын тэмдэгтийн хураамж төлөх цэсийг хөгжүүлэх ажлын даалгавар боловсруулж системийн хөгжүүлэлт хийгдэж дууссан,	100%	100%

						Зөвшөөрлийн цахим системээр хүсэлт хүлээн авах боломжтой болсон. Хавсралт: 1 файл		
3.6.	Судалгааны ажлын хуулбарлалтыг шалгах, эндаумент сангийн тогтолцоог бүрдүүлэх	-	-	-	-	1.Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны "Журам батлах тухай" А/332 дугаар тушаалын хавсралтаар "Судалгааны ажлын хуулбарлалтыг шалгах журам" батлагдсан. Дээд боловсролын сургалтын байгууллага, эрдэм шинжилгээний байгууллагын багш, судлаач, суралцагчийн эрдэм шинжилгээ, судалгааны ажил, бүтээлийн хуулбарлалтын хувь хэмжээг тогтоох, судалгааны ажлын нэгдсэн мэдээллийн санг бий болгох, түүнийг ашиглахтай холбоотой үйл ажиллагааг зохицуулах зорилгоор энэхүү журмыг боловсруулсан. Уг журмыг 2025 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн өмчийн хэлбэр үл харгалзан дээд боловсролын сургалтын байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага баримтлан ажиллахаар заасан. 2.Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн "Нийтлэг журам батлах тухай" А/331 дүгээр тушаалын хавсралтаар "Дээд боловсролын сургалтын байгууллагын эндаументын сангийн бүрдүүлэлт болон зарцуулалттай холбогдох нийтлэг журам"-ыг батлуулсан. Дээд боловсролын сургалтын байгууллагын	100%	100%

							<p>боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах, хөгжүүлэх мөнгөн хөрөнгө болон бусад хөрөнгөд суурилсан санг байгуулах, тус сангийн хөрөнгийг бүрдүүлэх, өсгөх, сангийн хөрөнгийн орлогыг зарцуулах, тайлагнах, хяналт тавихтай холбоотой зохицуулалтыг журамласан.</p> <p>Хавсралт: 2 файл</p>		
3.6.2 0	Судалгааны ажлын хуулбарлалтыг шалгах журмын батлуулна.	-	Сайдын тушаал	Журмын төслийг боловсруулсан.	Журмыг батлуулсан байна.	Журмын зохицуулалтын арга хэмжээ зохион байгуулна.	<p>Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны "Журам батлах тухай" А/332 дугаар тушаалын хавсралтаар "Судалгааны ажлын хуулбарлалтыг шалгах журам" батлагдсан. Дээд боловсролын сургалтын байгууллага, эрдэм шинжилгээний байгууллагын багш, судлаач, суралцагчийн эрдэм шинжилгээ, судалгааны ажил, бүтээлийн хуулбарлалтын хувь хэмжээг тогтоох, судалгааны ажлын нэгдсэн мэдээллийн санг бий болгох, түүнийг ашиглахтай холбоотой үйл ажиллагааг зохицуулах зорилгоор энэхүү журмыг боловсруулсан. Журмыг дээд боловсролын байгууллага, эрдэм шинжилгээний судлаач, багш суралцагч, Шинжлэх ухаан, технологийн сан, цахим дэд бүтэц хариуцагч даган мөрдөнө. Журмын дагуу бакалаврын дипломын ажил, магистрын төгсөлтийн ажил, докторын диссартац, эрдэм шинжилгээний өгүүлэл, төслийн тайлан, сурах бичиг, гарын авлага</p>	100%	100%

							болон нэг сэдэвт бүтээлийн хуулбарлалтыг шалгах боломжтой юм. Уг журмыг 2025 оны 01 сарын 1-ний өдрөөс эхлэн өмчийн хэлбэр үл харгалзан дээд боловсролын сургалтын байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага баримтлан ажиллахаар зааж өгсөн. Хавсралт: 1 файл		
3.6.2 1	Дээд боловсролын сургалтын байгууллагын эндаументын сангийн бүрдүүлэлт болон зарцуулалттай холбогдох нийтлэг журмыг батлуулна.	-	Сайдын тушаал	-	Журмын төслийг боловсруулна	Журмыг батлуулсан байна.	"Дээд боловсролын сургалтын байгууллагын эндаументын сангийн бүрдүүлэлт болон зарцуулалттай холбогдох нийтлэг журам"-ыг боловсруулж, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн "Нийтлэг журам батлах тухай" А/331 дүгээр тушаалаар батлуулсан. Дээд боловсролын сургалтын байгууллагын боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах, хөгжүүлэх мөнгөн хөрөнгө болон бусад хөрөнгөд суурилсан санг байгуулах, тус сангийн хөрөнгийг бүрдүүлэх, өсгөх, сангийн хөрөнгийн орлогыг зарцуулах, тайлагнах, хяналт тавихтай холбоотой зохицуулалтыг тусгасан. Хавсралт: 2 файл	100%	100%
Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ									
4.1.	Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт	-	-	-	-	-	Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, хууль тогтоомж, тогтоол	100%	100%

	бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээ болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хугацаанд нь цахим системд оруулж тайлагнах						шийдвэрийн биелэлт, Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө зэрэг урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан дээд боловсролын салбарт хамаарах арга хэмжээг газрын болон чиг үүргийн дагуу хариуцсан албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангуулж, биелэлтийг хугацаанд нь Төрийн мэдээллийн сүлжээ цахим системээр тайлагнасан.		
4.1.1	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг тайлагнах.	-	Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн тоо	2023 оны биелэлтийн хувь	Холбогдох заалтын хэрэгжилт хангагдсан байна.	Холбогдох заалтын хэрэгжилт хангагдсан байна.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн бүрэн хангуулж, биелэлтийг хугацаанд нь тайлагнасан. Хавсралт: 1 файл	100%	100%
4.1.2	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг тайлагнах	-	Зорилтын тоо, шалгуур, хэрэгжилтийн хувь	2023 оны тайлан	Хугацаанд нь тайлагнасан байна. Хэрэгжилт хангагдсан байна.	Хугацаанд нь тайлагнасан байна. Хэрэгжилт хангагдсан байна.	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан холбогдох заалтуудын хэрэгжилтийг хангуулж, биелэлтийг хугацаанд нь тайлагнасан. Хавсралт: 1 файл	100%	100%
4.1.3	Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт	-	Зорилтын тоо, шалгуур, хэрэгжилтийн хувь	2022 оны тайлан	Хэрэгжилт хангагдсан байна. Хугацаандаа тайлагнасан байна.	Хэрэгжилт хангагдсан байна. Хугацаандаа тайлагнасан байна.	Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт салбарын чиглэлээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангуулж, биелэлтийг хугацаанд нь тайлагнасан.	100%	100%

	салбарын чиглэлээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнах.						Хавсралт: 1 файл		
4.1.4	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах	-	Зорилтын тоо, шалгуур, хэрэгжилтийн хувь	2023 оны тайлан	Хэрэгжилт хангагдсан байна. Хугацаандаа тайлагнасан байна.	Хэрэгжилт хангагдсан байна. Хугацаандаа тайлагнасан байна.	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг холбогдох заалтуудын хэрэгжилтийг хангуулж, биелэлтийг хугацаанд нь тайлагнасан. Хавсралт: 2 файл	100%	100%
4.2.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах	-	-	-	-	-	Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох болон боловсруулсан дүрэм, журамд олон нийтийн саналыг авах зорилгоор Боловсролын яамны цахим хуудсанд мэдээ, мэдээлэл, журам, нийтлэг шаардлагын төслийг байршуулан санал хүлээн авсан. Дээд боловсролын салбарын баримтлах буй бодлого, чиглэл цэсэд холбогдох тушаал, шийдвэрийг байршуулсан. Хавсралт: 2 файл	100%	100%
4.2.5	Яамны болон салбарын мэдээллийн	-	Мэдээллийн тоо, хэрэгжилтийн	2023 оны байршсан мэдээлэл	Нийтийн мэдээллийн ил тод	Нийтийн мэдээллийн ил тод	Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн	100%	100%

	ил тод байдлыг ханган ажиллана.		н хувь		байдлын тухай хуульд заасан бүх мэдээлэл байршсан байна.	байдлын тухай хуульд заасан бүх мэдээлэл байршсан байна.	хяналтыг бий болгох, батлагдах дүрэм, журамд олон нийтийн саналыг авах зорилгоор Боловсролын яамны цахим хуудсанд журам, нийтлэг шаардлагын төслийг байршуулан санал хүлээн авсан. Дээд боловсролын салбарын баримтлах буй бодлого, чиглэл цэсэд холбогдох тушаал, шийдвэрийг байршуулсан. Хавсралт: 5 файл		
--	---------------------------------	--	--------	--	--	--	--	--	--

Үнэлсэн:

.....

.....

(албан тушаал)

.....

(гарын үсэг)

/...../

.....

(огноо)

Тайлагнасан:

.....

.....

(албан тушаал)

.....

(гарын үсэг)

/...../

.....

(огноо)